



Зорчигчийн хувийн хэрэглээ

Зорчигчийн хувийн хэрэглээний болон яаралтай тусламжийн эм бэлдмэлийг 7 хүртэлх өдрийн хэрэгцээг тооцож авч явахыг зөвшөөрнө.

Удаан хугацааны эмчилгээ шаарддаг өвчинд хэрэглэдэг эмийг зорчигчийн хувийн хэрэглээнд зориулан хилээр нэвтрэх зөвшөөрлийг 2 болон 3 дугаар шатлалын эмнэлгийн байгууллагын магадлагааг үндэслэн мэргэжлийн хяналтын байгууллага олгоно.

Зорчигчийн хувийн хэрэглээнд зориулан дараах төрлийн эмийг авч явахыг хориглоно. Үүнд:

1. Судсаар сэлбэх шингэн
2. Антибиотик тариа
3. Мансууруулах эм
4. Цусны бэлдмэл, сийвэн орлох эм
5. Нийтлэг дархлаажуулалтанд хэрэглэх эм

Эмийн хаяглалт, тэмдэглэгээ

Эмийн сав, баглаа боодол дээрх хаяглалт, тэмдэглэгээ нь дараах мэдээллийг агуулсан байна.

1. эмийн худалдааны болон олон улсын нэр, хэлбэр
2. тун, хэмжээ, тоо ширхэг
3. үйлдвэрлэгчийн нэр
4. цувралын дугаар
5. хэрэглэх арга
6. үйлдвэрлэсэн он, өдөр, хүчинтэй хугацаа
7. олгох нөхцөл
8. хадгалах нөхцөл
9. Монгол Улсын эмийн бүртгэлийн дугаар

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ЭКСПОРТ ИМПОРТ ХИЛИЙН ХОРИО ЦЭЭРИЙН
ХЯНАЛТЫН ХЭЛТЭС
ЭМ БИОБЭЛДМЭЛИЙН ХЯНАЛТ

